

Орчин үеийн геополитикийн хувьсал: Онолын төөрөгдөл, олон төвт тодорхойгүй төлөв байдал

Гунгаагийн Базарваань

Доктор (Ph.D), эрхлэгч, bazarvaani.g@uia.gov.mn

Монгол Улс, Улаанбаатар, Дотоодын Их сургуулийн аюулгүй байдал судлалын төв

Хураангуй

Энэхүү өгүүлэлд орчин үеийн геополитикийн өөрчлөлт, хүчний төвүүдийн стратегийн өрсөлдөөнийг онолын үзэл баримтлал болон бодит нөхцөл байдлын уялдаа холбоонд тулгуурлаж шинжилсэн болно. АНУ, БНХАУ, ОХУ-ын гурвалсан харилцаа XXI зуунд дэлхийн гол тэнхлэг болж, их гүрнүүдийн өрсөлдөөн даяарын¹ тогтвортой байдал болон бүс нутгийн аюулгүй байдалд хүчтэй нөлөө үзүүлж байна. Судалгаанд реализм, либерализмын онолын хандлага, олон төвт тогтолцооны онцлогийг авч үзэхийн зэрэгцээ эдийн засаг, технологи, дэд бүтэц, мэдээллийн орон зайг хамарсан “олон хэмжигдэхүүнт геополитик” хэмээх үзэгдлийг онцоллоо. Мөн жижиг, дунд улсад оновчтой маневр хийх боломж хумигдаж буйг тэмдэглэж, стратегийн шийдвэр гаргалт болон ашиг сонирхлын тэнцвэрийг хадгалах шаардлагыг тодотгов. Энэхүү өгүүлэл орчин үеийн геополитикийн орчин онолын төөрөгдөл үүсгэж, улмаар стратегийн өрсөлдөөнийг гааруулж, олон улсын дэг журмыг өөрчилж буй явцыг ойлгоход хувь нэмэр үзүүлнэ.

Түлхүүр үг: Геополитикийн хувьсал, онолын төөрөгдөл, хүчний гурвалжин, геополитикийн хэрэгсэл, орчин үеийн олон улсын харилцаа.

Оршил

Сүүлийн арван жилд дэлхийн геополитикийн бүтэц огцом өөрчлөгдөж, олон улсын системийн тэнцвэр “тодорхойгүй” хэлбэрт шилжиж байна. Хүйтэн дайнаас хойш либерал дэг журмыг дэлгэрүүлэгчийн дүр төрхөөр АНУ олон улсын харилцаанд жанжлагч байхын тулд эдийн засаг, улс төр-цэрэг, технологийн давуу талаараа дэлхийн дэг журмыг хүчээр чиглүүлж ирсэн. Гэвч XXI зууны хоёр дахь арван жилээс БНХАУ-ын хурдацтай өсөлт, ОХУ-ын геополитикийн идэвхтэй үйлдэл АНУ-ын ноёрхлыг сорихуйц шинэ нөхцөл байдлыг үүсгэсэн юм. Энэ нь олон улсын харилцаанд тодорхойгүй байдлыг үүсгэх нэг шалтгаан болж, геополитикийн өрсөлдөөнийг хурцатгаж байна. Тухайлбал:

Нэгдүгээрт, БНХАУ-ын эдийн засгийн өсөлт, чадавх АНУ-ын дараа эрэмбэлэгдэж, дэлхийн худалдаа, технологи, эрчим хүчний зах зээлд нөлөөлөх түвшинд хүрсэн. Үүний зэрэгцээ Хятадын ДНБ 2010–2023 онд дөрөв дахин өссөн төдийгүй тус

¹ глобал

улс дэлхийн үйлдвэрлэлийн 30 орчим хувийг үйлдвэрлэх болсон явдал АНУ-ын эдийн засгийн давамгайл байдлыг сорьж байна. Түүнчлэн БНХАУ-ын “Made in China 2025”² болон хиймэл оюун, квант технологийн хөтөлбөрүүд нь стратегийн салбаруудад давуу байдлыг үүсгэж болзошгүй байгаагаас хоёр улсын хооронд зөвхөн худалдааны дайн бус технологийн өрсөлдөөнийг эрчимжүүлж байна.

Хоёрдугаарт, ОХУ 2014 онд Крымыг нэгтгэсэн явдал Европын аюулгүй байдлын тогтолцоог өөрчилсөнтэй холбоотойгоор Өрнөдийн хориг арга хэмжээ болон НАТО-ын дорно жигүүрийн батлан хамгаалах бодлого хурцадсан. Улмаар Орос-Украины зэвсэгт мөргөлдөөн АНУ–ОХУ-ын харилцааг “Хүйтэн дайн”-ы үеийн түвшинтэй дүйцэхүйц зөрчилтэй байдалд хүргэж, дэлхийн хүчний тэнцвэрийг дахин хуваарилах хүчин зүйл болж байна.

Гуравдугаарт, ОХУ-БНХАУ-ын стратегийн түншлэл гүнзгийрч, эрчим хүч, худалдаа, батлан хамгаалах салбарт хамтын ажиллагаа өргөжиж байна. Ялангуяа, Өрнөдийн хориг арга хэмжээтэй холбоотойгоор ОХУ-ын эдийн засаг БНХАУ-ын зах зээлээс илүү хамааралтай болж, хоёр улсын худалдааны хэмжээ 2023 онд 240 тэрбум ам.долларт хүрч түүхэн дээд түвшинд хүрсэн явдал АНУ-ын геостратегийн байр сууринд нөлөөлөхүйц шинэ тэнцвэрийг бий болголоо.

Эдгээр өөрчлөлт АНУ–БНХАУ, АНУ–ОХУ, ОХУ–БНХАУ-ын харилцааг гурвалсан бүтэцтэй, хоорондоо уялдаа бүхий стратегийн өрсөлдөөнд хүргэж, дэлхийн хүчний төвийг Ази–Евроазийн орон зайд улам бүр чиглүүлэх болж байна.

Том гүрнүүдийн өрсөлдөөн жижиг улсуудад гадаад бодлогоо улам бүр уян хатан явуулах, ашиг сонирхлын тэнцвэрийг хангах хүчин чармайлтаа мөн адил нэмэгдүүлэхэд хүргэхийн зэрэгцээ эргээд аль нэг бүлэглэлд багтахгаас өөр сонголтгүй нөхцөл байдлыг тулгаж болзошгүй хандлага бий болж байна. Энэхүү нөхцөл байдлаас улбаалж дунд улсууд олон улсын харилцаанд идэвхтэй тоглогч байж, бүс нутагтаа тэргүүлэх өрсөлдөөнийг өрдөж буй зэрэг үйл явц өнөөгийн олон туйлт болон олон хэмжээст дэглэмийг төлөвшүүлж байна.

Энэхүү өгүүлэлд орчин үеийн геополитикийн хувьслыг онолын хандлага болон бодит үйл явдалд тулгуурлаж шинжлэхийг зорьсон болно.

Нэг. “Их гурвалжин”-ы харилцаа, онолын үндэслэл

Олон улсын харилцааг геополитикийн хүчин зүйлс, тухайн улсын эдийн засгийн чадавх, газар зүйн байршил, хүчний харьцаа болон хүчний төвүүд³ тодорхойлдог. Эдүгээ эдгээрээс олон улсын амьдралд гарч байгаа хүчний өөрчлөлтийн шинж байдлыг онолын чиг хандлагууд угтаа хэрхэн тодорхойлж байсныг эргэн санацгаая.

² БНХАУ 2015 онд зарласан үндэсний хэмжээний үйлдвэржилтийн дунд хугацааны стратеги. Уг стратегийн дагуу тус улс 2025 он гэхэд дэвшилтэт үйлдвэрлэлийн дэлхийн тэргүүлэгч орон болох зорилготыг хэрэгжүүлж байна. Энэ нь Хятадын эдийн засгийг “бөөний хямд үнэтэй үйлдвэрлэл”-ээс “өндөр технологи, чанартай, инновацтай үйлдвэрлэл”-д шилжих үндсэн хөтөлбөр юм.

³ “Хүчний төв” (power center) гэдэг олон улс болон бүс нутгийн түвшинд бусад оролцогчийн бехавиор, шийдвэр, аюулгүй байдлын нөхцөлд бодитой нөлөө үзүүлэх хангалттай нөөц, чадавх, легитим нөлөөг төвлөрүүлсэн улс, эвсэл, институт болно.

Тухайлбал: Реализмын (structural/neo-realism) онол олон улсын харилцааг хүчний тэнцвэр тодорхойлдог хэмээн үздэг. К.Уолтцын тодорхойлсноор олон улсын харилцаа анархи шинжтэй учир улс орон өөрийн аюулгүй байдлыг хангахын тулд хүч, нөлөөллийн өрсөлдөөнд байнга татагдах явдал зүй ёсны төдийгүй логикт нийцсэн үйл явц аж.⁴ Үүгээр АНУ дэлхийд ноёрхлоо хадгалахыг хичээх, БНХАУ олон улсын харилцаанд нөлөөлөх байр суурьтай болохыг зорих, ОХУ геополитикийн нөлөөллөө сэргээхийг эрмэлзэх явдал зүй ёсных төдийгүй энэхүү стратегийн гурвалжин үл тасрах хэв шинжийг агуулж байна. Өөрөөр хэлбэл: АНУ, БНХАУ, ОХУ-ын өрсөлдөөн хувьсамтгай үзэгдэл бус, харин олон улсын системийн хүчний бүтэцтэй салшгүй холбоотой тогтвортой гурвалжин аж. Судлаачид үүнийг “Power Triangle”, эсвэл “BMW” (Beijing–Moscow–Washington) гурвалжин хэмээн нэрлэдэг.⁵

Нөгөөтгээгүүр, энэхүү харилцан хамаарал бүхий сөргөлдөөн эдгээр улс оршин тогтнох бүхий л цаг хугацаанд орших төдийгүй гагцхүү эрх ашгийн үүднээс аль нэг хоёр улс нь ойртох, эсвэл холдох үзэгдэл зайлшгүй. Эдүгээ Өрнөдийг сөрөх Москва, Бээжингийн ашиг сонирхол Вашингтоны эсрэг нэгдэж буй ч Хятадын өсөлт ОХУ болон АНУ-ын хувьд “далд шаналан” болж буй нь тодорхой. Иймээс хүчний тэнцвэрийг хангах үүднээс Москва-Вашингтоны нэгдэл (conditional alignment) үүсэх явдал цаг хугацааны асуудал болно.

Бээжин-Москва-Вашингтоны стратегийн зорилгыг реалист үзэл баримтлалын хувьд дараах байдлаар нэгтгэж үзэж болно.

Хүснэгт 1. “Их гурвалжин”-ы стратегийн зорилго, онолын хандлага

Хүчний төв	Стратегийн зорилго	Реалист үзэл баримтлал
АНУ	Давуу байр сууриа хадгалах, Хятадын өсөлтийг хязгаарлах	Hegemonic stability theory
БНХАУ	Олон туйлт тогтолцоонд илүү жинтэй байр эзлэх, дэлхийн их гүрэн болох	Power transition theory
ОХУ	Нөлөөллийн хүрээгээ сэргээх, стратегийн хүчний тэнцвэрт оролцох	Sphere of influence

Онолын дээрх чиг хандлагаар авч үзвэл “Их гурвалжин”-гийн харилцаа тогтвортой, тасалдашгүй төдийгүй системийн түвшний анархи шинж чанартай болохыг бодит байдалд харуулж буйн сонгодог жишээ юм. Энэ нь том гүрнүүд тодорхой цаг үед үр ашигтай “тактикийн эвсэл” үүсгэж болох ч тэдний хооронд урт хугацааны стратегийн өрсөлдөөн тасралтгүй үргэлжлэх логикийг нотолж байна.

Либерализмын онол олон улсын тогтолцоонд институт, эрх зүй, худалдаа, харилцан хамаарал зөрчилдөөнөөс урьдчилан сэргийлж, хамтын ажиллагааг гүнзгийрүүлдэг хэмээн үздэг.⁶ Либерализмын хамгийн гол үзэл санаа бол улс орнууд

⁴ Waltz, K. Theory of International Politics, 1979, т-88.

⁵ Chubin, S. The Strategic Triangle in World Politics. 2021,

⁶ Keohane, R. & Nye, J. (1977). Power and Interdependence. Doyle, M. (1986). “Liberalism and World Politics.” American Political Science Review.

эдийн засгийн хувьд харилцан хамаарал өндөр байх тусам зөрчилдөөнөөс зайлсхийж, улс төрийн итгэлцлээ нэмэгдүүлж, энхийг эрхэмлэх хандлага давамгайлна хэмээсэнд оршино.⁷

Гэвч шинэ зууны геополитикийн өрсөлдөөн, ялангуяа АНУ-БНХАУ, Өрнөдийнхөн болон ОХУ-ын харилцаанд өрнөж буй үйл явц либерализмын онолын зарим суурь таамаглал бодит амьдрал дээр төдийлөн хэрэгжихгүй байгааг харууллаа. Тухайлбал:

1. Харилцан хамаарал ямагт энх тайван төрүүлдэг гэх таамаглал нэн ялангуяа том гүрнүүдийн хоорондын харилцаанд буюу бодит амьдрал дээр нотлогдохгүй байна. АНУ болон БНХАУ 2010-аад оны дунд үе гэхэд дэлхийн хамгийн гүнзгий харилцан хамааралтай эдийн засагтай улс байсан. Хоёр улсын худалдааны эргэлт 2018 онд 660 тэрбум ам.доллар давж, үндсэндээ бүх үйлдвэрлэлийн сүлжээ хоорондоо холбогдсон байв. Либерализмын онолын логикоор ийм өндөр түвшний харилцан хамаарал бүхий харилцаа худалдааны маргаан, тарифын сөргөлдөөн, технологийн өрсөлдөөнөөс ангид байх ёстой. Гэтэл 2018 оноос эхэлсэн Вашингтон Бээжингийн худалдааны дайн (Trade War) эсрэг дүр зургийг бүтээсэн юм. Тодруулбал: Хятадын бараанд Америк олон тэрбум ам.долларын тариф ногдуулж, Бээжин хариу арга хэмжээ авсан явдал эдийн засгийн харилцан хамаарал зөрчилдөөнөөс зайлсхийх баталгаа бус, эсрэгээрээ харилцан хамаарлыг зэвсэгжүүлэх (Weaponized Interdependence) үзэгдэл үүсгэх боломжтойг харуулав. Өөрөөр хэлбэл: либерализмын онолд өгүүлдэг шиг харилцан хамаарал зөрчил бууруулах бус, харин гео-эдийн засгийн дарамт, шахалтын хэрэгсэл болж хувирчээ.
2. Хамтын аюулгүй байдлыг олон улсын институт бүрэн хангах боломжгүй байна. Либерализмын онолын өөр нэг тулгуур ойлголт бол олон улсын байгууллагууд улс орны харилцааг зохицуулж, зөрчилдөөнөөс ангид байлгах ба хамтын аюулгүй байдлын тогтолцоо үүнд чухал үүрэгтэйг онцолдог. Гэтэл ОХУ-ын эсрэг Европын Холбоо, АНУ тэргүүтэй Өрнөдийнхний авсан өргөн хүрээний хориг арга хэмжээ олон улсын байгууллагын зохицуулах оролцоог хумьж, том гүрнүүдийн эрх ашигт л үйлчлэх боломжтойг харуулж байна. Тухайлбал: НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлд Орос хоригийн эрхтэй тул тус институцийн аливаа шийдвэр хүчин мөхөстсөн, мөн Москвагай харилцаагаа хадгалж үлдэх үүднээс Хятад, Энэтхэг болон Зүүн Өмнөд Азийн улсууд Өрнөдийн хоригт нэгдээгүй. Энэ нь олон улсын системээс ОХУ-ыг тусгаарлах, дэлхийн эдийн засгийн харилцааг бүрэн таслах боломжгүйг нотолсны зэрэгцээ либерализмын “институт тогтвортой байдлыг хангана” гэх зарчим бодит байдалд геополитикийн зөрчлийг бууруулах чадамж нь хязгаарлагдмал гэдгийг харууллаа.

⁷ Keohane, R. & Nye, J. (1977). Power and Interdependence.

3. Олон улсын эрх зүй, институт том гүрнүүдийн ашиг сонирхлыг хязгаарлах боломжгүйг илчилж байна. Ерөөс олон улсын байгууллагуудын нөлөө жижиг, дунд улсад өндөр, харин их гүрнүүдийн хувьд төдийлөн нөлөөгүй болохыг сүүлийн үеийн аюулгүй байдлын судалгааны үр дүнд тэмдэглэх болсон.⁸ Эдүгээ өрнөж буй үйл явцыг ажиглавал аливаа үйл явц том гүрнүүдийн үндэсний ашиг сонирхолд нөлөөлөх тохиолдолд олон улсын байгууллага, эрх зүй тэдэнд үйлчлэхгүйг нотолж байна. Тодруулбал: АНУ-ын тарифын бодлогыг ДХБ хязгаарлаж, Украины мөргөлдөөнийг НҮБ зогсоож, ОУВС болон ДХБ геоэдийн засгийн өрсөлдөөнийг сааруулж чадсангүй.

Энэ гурван тохиолдол үндсэндээ либерализмын онолын гол шүүмжлэлийг бий болгож байна.

Хоёр. Геополитикийн орчин үеийн хандлага, олон төвт тогтолцоо

Эдүгээ геополитикийн өрсөлдөөн уламжлалт “нутаг дэвсгэр–цэргийн хүч”-д тулгуурласан парадигмаас хальж, улам бүр олон талыг хамарсан өрсөлдөөн болон хувирч байна. Ингэснээр геополитик дан ганц улс гүрнүүдийн газар нутгийн төлөөх (орон зайн) ашиг сонирхлын зөрчлөөр хязгаарлагдалгүй, эсрэгээрээ эдийн засаг, дэд бүтэц, технологи, мэдээллийн орон зай дээр суурилсан стратегийн өрсөлдөөнийг гүнзгийрүүлж буй.

Ингэснээр геополитикийн орчин үеийн хандлагууд онолын төөрөгдлийг бий болгож байна. Тухайлбал: Олон төвт тогтолцооны өрнөл хүчний шинэ төвүүдийг бий болгохын хэрээр өнөөгийн олон улсын харилцаанд тогтсон хүчний тэнцвэрийг алдагдуулж, даяарын амьдралд шинэ дэг журам үйлчлэх нөхцөлийг бүрдүүлж буй. Хүйтэн дайны дараах олон улсын харилцаанд АНУ давамгайлж, нэг туйлт тогтолцоо тогтносон бол XXI зууны хоёрдугаар арван жилээс дэлхийн геополитикийн архитектур олон төвт хэв шинжид шилжиж эхэлсэн. Энэ нь улс төр, батлан хамгаалах, эдийн засаг, технологийн талбарт хүчний олон төв үүсэж буйгаар илэрлээ.

Судлаачид АНУ-ын давамгайлал суларч буйг дараах хүчин зүйлээр тодорхойлж байна. Үүнд:

1. *БНХАУ-ын эдийн засгийн нөлөө.* Тус улс 2010 онд дэлхийн хоёр дахь том эдийн засаг болж, 2023 оноос олон салбарт АНУ-ыг гүйцэж эхэлсэн.
2. *ОХУ-ын геостратегийн сэргэлт.* Крым, Сири дэх ОХУ-ын оролцоо Москвагийн геополитикийн эргэн ирэлтийг илтгэсэн.
3. *Даяарын Өмнөдийн улс төрийн идэвхжил.* Энэтхэг, Турк, Саудын Араб, Бразил, Индонез зэрэг дунд гүрэн бүс нутгийнхаас “глобал” тоглогч болох боломжийг эрэлхийлж эхэлсэн.
4. АНУ-ын дотоодын улс төрийн туйлшрал, стратегийн сарнил. Нэгдсэн Улс XXI зуун гарсаар “Дахин тэнцвэржүүлэх”, “Эн тэргүүнд Америк” зэрэг

⁸ Mearsheimer, J. (2019). “Bound to Fail: The Rise and Fall of the International Order.” *International Security*.

бодлогыг хэрэгжүүлж тус улсын стратегийн хүндийн төв чухам хаашаа эргэх нь тодорхойгүй болсон явдал олон улсын тавцанд эзлэх Вашингтоны жин нөлөөг хумьсан зэрэг үйл явц багтаж байна.

Эдүгээ бүрэлдэж буй олон төвт тогтолцоо улс гүрэн, институтийн холимог төдийгүй улс орны улс төрийн дэглэмийг үл харгалзах шинжтэй байгаагаараа өмнөх хоёр туйлт тогтолцооноос ялгагдах өвөрмөц бүтцийг бүрэлдүүлэх хандлагатай байна хэмээн үзэж болох мэт. Хэдийгээр олон улсын харилцаа, аюулгүй байдал судлаачид дэлхийн шинэ дэг журмын талаар хөндөх болсон ч чухам яг ямар дэг бий болохыг таамаглаж чадахгүй байгаа явдал энэхүү өвөрмөц гэх байдалтай холбоотой болов уу. Тухайлбал: институтийн түвшинд бүрэлдэж буй “Даяарын Өмнөд” бүлэгт БНХАУ, ОХУ зэрэг авторитар дэглэмтэй улс багтахын зэрэгцээ Энэтхэг, Бразил зэрэг ардчилсан улс мөн нэгдэж байна. Гэхдээ энэ бүлэглэлийг хэн манлайлах нь тодорхойгүй, жанжлалын төлөөх дотоод өрсөлдөөн уг институтийн цаашдын төлөвшилд шууд нөлөөлөх эрсдэлтэй, тодорхойгүй бүтэц. Гэтэл үүнийг сөрөх “Хамтын Өрнөд”-ийн бүлэг мөн адил дотроо Европын Холбоо VS Унгар болон Европын Холбоо VS АНУ гэх хоёр дэд бүлэгт хуваагдаж болзошгүй байна. Үүний дээр НҮБ, ДХБ зэрэг уламжлалт институтийн үүрэг оролцоо сул болсон явдал эдүгээ олон улсын эрх зүйд тогтсон хэм хэмжээг улс орнууд, үүний дотор том гүрнүүд илэрхий зөрчихөд хүргээд байна.

Энэ мэт даян дэлхийд үүссэн геополитикийн өвөрмөц нөхцөл байдал дэлхийн дэг журмыг өөрчлөх төдийгүй бидний хэлэлцэж буй шинэ дэг журам онолын дэг сургуулиас гагцхүү реализмд түшиглэх хандлага тодорч болзошгүй байна. Үүгээр олон улсын харилцаанд цаашид таамаглахад бэрх олон нөхцөл байдал үүсэх нь илэрхий. Өөрөөр хэлбэл: олон төвт тогтолцоо АНУ-ын хүчний нөлөөллийг огцом бус боловч аажмаар сулруулахын хэрээр том гүрнүүдийн өрсөлдөөн илүү эрчимтэй, олон талтай өрнөж, олон хямрал үүсэж болзошгүй юм.-

Энэхүү хувьсал геополитикийн өрсөлдөөнийг уламжлалт бус болгов. Тухайлбал: геоэдийн засаг, эрчим хүч, технологийн хөгжил шинэ өрсөлдөөнийг бий болгож, геополитикийн өрсөлдөөнд эдийн засгийн шахалт чухал хэрэгсэл боллоо. Өөрөөр хэлбэл: XXI зуунд эдийн засгийн харилцан хамаарал улс гүрний хооронд энх тайван тогтоох хүчин зүйл байхаас илүүтэйгээр стратегийн шахалт, нөлөөллийн гол хэрэгсэл болж хувирч байна. Тодруулбал: БНХАУ-ын “Бүс ба Зам” санаачилга, АНУ-ын “Энэтхэг-Номхон далайн бүс нутгийн эдийн засгийн түншлэлийн формат” (IPEF), ОХУ-ын “Евроазийн эдийн засгийн холбоо”, Европын Холбооны “Global Gateway” зэрэг өргөн хүрээний дэд бүтэц, геополитикийн стратеги бүс нутгийн улс орныг эдийн засгийн хараат байдал, геополитикийн талцалд хөтөлж байна. Энэ нь хөгжиж буй улс орнуудад “сонголтын геополитик” (geopolitics of choice) гэх шинэ сорилтыг үүсгэх буюу нэг талыг барихгүй, илүү прагматик (зарим тохиолдолд ультра-прагматик) байхыг шаардахын зэрэгцээ газар зүй, эдийн засгийн орон зайн хувьд аль нэг талд багтахаас өөр сонголтгүй болгох хүнд нөхцөлийг тулгаж байна.

Геополитикийн өөр нэг хэрэгсэл бол эрчим хүчний бодлого. Европын Холбоо өмнө нь байгалийн хийн хэрэглээнийхээ 40 орчим хувийг ОХУ-аас авч байсан. Гэвч Орос-Украины дайнаас улбаалж, Москва Брюсселийн харилцаа хүйтэрснээр тус холбоонд эрчим хүчний асар том “геоэдийн засгийн хямрал” үүссэн бол ОХУ-д “сонголтгүй нийлүүлэлт”-ийн тогтолцоо бий болж, энэ хэрээр БНХАУ-аас хамааралтай болж байна. Энэ нь мөн эрчим хүчний нөөц бүтээгдэхүүний үнэд ч нөлөөлж буй. Үүнтэй холбоотойгоор Саудын Араб, Катар, Орос зэрэг улс эрчим хүчний нийлүүлэлтийнхээ үнийг геополитикийн хэрэгсэл болгож байгааг Газрын тос олборлогч улсуудын байгууллага (ОПЕК)-ийн өнөөгийн стратегиас харж болохоор байна.

Энэ логикоор авч үзвэл газрын ховор элементийн 80 хувийг нийлүүлж, дэлхийн хэмжээнд ноёрхож байгаа Бээжинд эдгээр эрдэс шинэ төрлийн “стратегийн хамаарал” бий болгох хэрэгсэл болж байна. Түүнчлэн технологийн хөгжил ч геополитикийн хэрэгсэл болов. Эдүгээ БНХАУ болон АНУ-ын хооронд зөвхөн худалдааны бус технологийн дайн өрнөж буй. Тухайлбал: 5G технологитой холбоотойгоор АНУ “Huawei”-г хориглож, бичил дамжуулагч чипний тоног төхөөрөмжийг БНХАУ-д экспортлохыг хязгаарласан явдал технологийн хөгжил “үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн” хэсэг болж байгааг илтгэж байна. Үүнд мөн хиймэл оюуны асуудал багтана. Хэтдээ дэлхий нийт энэ хоёр улсын хэнийх нь технологийг сонгох гэх сорилттой тулгарах болно.

Дүгнэлт

XXI зууны геополитикийн хувьсал олон улсын системийн суурь логик, хүчний бүтэц, стратегийн өрсөлдөөнийг бүхэлд нь шинээр тодорхойлж болзошгүй үйл явцыг эхлүүллээ. Үүгээр АНУ, БНХАУ, ОХУ-ын өрсөлдөөн дэлхий дахины тогтвортой байдал, бүс нутгийн аюулгүй байдал болон олон улсын дэг журмын хэв шинж үлэмж өөрчлөгдөхөд нөлөөлөх болно.

Өнөөгийн нөхцөл байдлаас үзвэл дараах таамаглалыг дэвшүүлж болохоор байна:

Нэгдүгээрт, реализмын онолын тайлбар орчин үеийн олон улсын харилцаанд илүү бодитой нийцэж байна. Хүчний тэнцвэр, ноёрхлын тэмцэл, аюулгүй байдлын тодорхойгүй байдал том гүрнүүдийн харилцан үйлдэлд хүчтэй нөлөөлж, “Их гурвалжин”-ы хооронд эв санааны тогтвортой нэгдэл бус харин богино хугацааны ашигт суурилсан “тактикийн түншлэл” давамгайлахаар байна.

Хоёрдугаарт, либерализмын үндсэн ойлголт болох харилцан хамаарал, олон улсын институтийн нөлөө, олон улсын эрх зүйд суурилсан дэг журам том гүрнүүдийн стратегийн өрсөлдөөний улмаас хэрэгжих нь улам бүр хязгаарлагдах болсныг сүүлийн арван жилийн үйл явц тод харууллаа. Худалдааны өндөр хамаарал ч энх тайвны баталгаа болж чадахгүй болохыг АНУ–БНХАУ-ын “харилцан хамаарал” харуулж, цаашид хоёр улсын өрсөлдөөн стратегийн сөргөлдөөн болох чиглэлд улам бүр чиглэхээр байна.

Гуравдугаарт, олон төвт тогтолцоо бүрэлдэж байгаа ч энэ нь тогтвортой, тэнцвэржсэн бүтэц биш, харин тодорхойгүй байдал, эрсдэл давамгайлсан шилжилтийн үе шат байх болно. Шинэ туйл болох магадлалтай гэгдэж буй БНХАУ-ын өсөлт, ОХУ-ын геостратегийн эргэн ирэлт, АНУ-ын жанжлалын төлөөх бодлого дэлхий дахиныг урьдчилан таамаглахад бэрх, төвөгтэй дэг журам руу түлхэхээр байна.

Дөрөвдүгээрт, эдийн засаг, технологи, дэд бүтэц, мэдээллийн орон зайг хамарсан “олон хэмжээст геополитик” уламжлалт бус стратегийн өрсөлдөөний шинэ фронтыг бүрдүүлж байна. Хиймэл оюун, квант технологи, эрчим хүчний сүлжээ, дэлхийн нийлүүлэлтийн гинжин хэлхээ зэрэг салбар геополитикийн гол хэрэгсэл болохоор байна.

Тавдугаарт, энэ тогтворгүй, тодорхойгүй орчин жижиг, дунд улсын аюулгүй байдлын маневрлах орон зайг улам бүр хумьж, тэнцвэржүүлэх, ашиг сонирхлын тэнцвэрийг барих олон тулгуурт дипломат бодлогыг зайлшгүй хэрэгжүүлэх төдийгүй аль нэг төвд дайгдахаас өөр сонголтгүй болохоос сэрэмжлэх бодлогыг тус тус шаардах болно.

Ийнхүү орчин үеийн геополитикийн хувьсал зөвхөн шинэ төвүүдийн үүсэл төдий бус, онолын түвшинд нэгдмэл ойлголт төөрөгдөх, системийн хэмжээнд тодорхойгүй байдал, стратегийн өрсөлдөөн эрчимжих шинэ эрин эхэлж буйг нотолж байна. Энэ нөхцөлд онолын төөрөгдлийг арилгах, бодлогын шинжилгээг улам нарийвчлах, бүс нутгийн тогтвортой байдлыг хангах арга хэрэгслийг шинээр боловсруулах шаардлага аюулгүй байдлын судлалд тулгарлаа.

Эх сурвалжийн жагсаалт

Waltz, K. *Theory of International Politics*, 1979, т-88.

Chubin, S. *The Strategic Triangle in World Politics*. 2021,

Keohane, R. & Nye, J. (1977). *Power and Interdependence*.

Doyle, M. (1986). “Liberalism and World Politics.” *American Political Science Review*.

Mearsheimer, J. (2019). “Bound to Fail: The Rise and Fall of the International Order.” *International Security*.

Contemporary Geopolitical Evolution: Theoretical Ambiguities and the Uncertain State of Multipolarity

Bazarvaani Gungaa

Doctor (Ph.D), Chief of the Center, Research Institute, bazarvaani.g@uia.gov.mn
Center for Security Studies, University of Internal Affairs, Ulaanbaatar, Mongolia

Abstract

This article examines contemporary geopolitical transformations, the evolving structure of international power, and patterns of strategic competition through an integrated analysis of theoretical frameworks and empirical developments. In the 21st century, trilateral relations among the United States, China, and Russia have emerged as a central axis of global politics, with great power competition exerting substantial influence on international stability and regional security dynamics. Drawing on realist and liberal perspectives, the study analyzes the characteristics of an increasingly multipolar international system and argues that ongoing geopolitical processes challenge the explanatory boundaries of established international relations theories, generating growing theoretical ambiguity. The article introduces the concept of “multidimensional geopolitics” to capture the expansion of strategic competition into economic, technological, infrastructural, and informational domains, where power is exercised in non-military and hybrid forms. It further highlights the narrowing strategic maneuvering space available to small and medium-sized states, underscoring the necessity of adaptive strategic decision-making and interest balancing under conditions of structural uncertainty. Overall, the article contributes to scholarly debates on theoretical ambiguity, great power competition, and emerging risks to the contemporary international order.

Keywords: *Geopolitical Evolution, Theoretical Paradox, Power Triangle, Geopolitical Tool, Contemporary International Relations.*

Received: November 30, 2025 | Accepted: December 23, 2025 | Published online: December 30, 2025



© The Author(s) 2025

<https://creativecommons.org/licenses/by/4.0/>.